

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ДОА-2025/004/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 7056-2112, Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10-14
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан.....	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 376

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.ГУНГААЦЭРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,180.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1. Батлагдсан төсвөөс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахгүйгээр 71.7 сая төгрөгийн 2 арга хэмжээний зардлыг шууд гэрээ байгуулж гаргасан;
2. Тайлант оны эцэст үүссэн 1.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
3. Байгууллага нь өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгө, 20.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө /тоног төхөөрөмж/-ийг хуулийн этгээдэд ашиглуулахдаа "эд хөрөнгийн ашиглалтын гэрээ"-г байгуулаагүй;
4. Бараа материалын мал амьтад дансанд бүртгэлтэй мал /хуц, ухна/-ын тоо жилийн эцсийн мал тооллогын комиссын тоолсон малын дүнтэй зөрүүтэй;
5. Сумын ОНХС-гийн хөрөнгөнөөс иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй "Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" төсөл

232520378

арга хэмжээнд 20.0 сая төгрөгийг төлөвлөн, гүйцэтгэлээр 16.7 сая төгрөгийг зарцуулсан;

- Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл бууны татвар 42.5 хувь буюу 0.5 сая төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамж 60.0 хувь буюу 0.7 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай АМНАТ 100 хувь буюу 15.0 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 60.3-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, ... зардал, арга хэмжээ", Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэж заасныг зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хоршоо хөгжүүлэх сангийн 49.6 сая төгрөгийн зээл болон зээлийн хүүг хувийн дансаар дамжуулан авсан залилангийн шинж чанартай асуудал илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Бусад асуудлын хэсэг

Баянтүмэн сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг "Хангалтгүй" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	934,545.80	1,263,366.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	604,994.20	915,232.10
33	АВЛАГА	176,912.00	149,693.30
35	БАРАА МАТЕРИАЛ	152,639.60	195,941.10
36	НӨӨЦИЙН БАРАА	0	2,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,786,348.40	3,803,687.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,786,348.40	3,803,687.80
39200	Биет хөрөнгө	2,546,865.10	3,598,037.80
39300	Биет бус хөрөнгө	239,483.20	205,650.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,720,894.10	5,067,054.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	97,817.50	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	97,817.50	0
41300	Өглөг	97,817.50	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,623,076.60	5,067,054.20
51	Засгийн газрын хувь оролцоо	3,623,076.60	5,067,054.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	642,586.80	642,586.80
51200	Хуримтлагдсан үр дүн	2,746,903.00	4,138,101.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	233,586.80	286,365.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,720,894.10	5,067,054.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,076,616.50	5,080,570.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,635,561.30	2,108,137.20
110	Орлогын албан татвар	965,596.10	1,215,268.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	975,579.00	1,264,342.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,982.90	-49,074.10
113	Хөрөнгийн албан татвар	222,615.30	75,462.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	447,349.90	817,406.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	786,745.70	1,758,447.20
120	Нийтлэг татварын бус орлого	756,395.70	1,554,066.50
122	Тусламжийн орлого	30,350.00	204,380.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,654,309.60	1,213,986.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,703,878.70	2,225,368.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,703,878.70	2,225,368.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,415,300.50	1,893,422.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,697.70	835,584.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,808.20	100,695.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,786.00	112,866.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,779.00	101,449.00

**БАЯНТҮМЭН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2105	Нормативт зардал	2,325.80	14,172.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,610.30	24,924.20
2107	Томилолт, зочны зардал	11,267.00	12,791.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,836.70	9,151.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	598,189.70	681,787.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,288,578.20	331,945.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,372,737.90	2,855,202.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	883,993.10	1,411,641.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	488,744.70	1,443,560.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,134,331.90	3,134,331.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,134,331.90	3,134,331.90
9	Тайлант үеийн үр дүн	488,744.70	488,744.70
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,623,076.60	3,623,076.60
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,623,076.60	3,623,076.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,037.80	1,037.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,624,114.40	3,624,114.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-621.2	-621.2
19	Тайлант үеийн үр дүн	1,443,560.90	1,443,560.90
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,067,054.20	5,067,054.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,481,598.30	3,772,267.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,635,561.30	2,108,137.20
110	Орлогын албан татвар	965,596.10	1,215,268.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	975,579.00	1,264,342.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,982.90	-49,074.10
113	Хөрөнгийн албан татвар	222,615.30	75,462.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	447,349.90	817,406.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,616.90	1,950.20
1181	Газрын төлбөр	406,733.00	815,456.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,501.70	451,018.60
120	Нийтлэг татварын бус орлого	160,151.70	246,637.90
122	Тусламжийн орлого	30,350.00	204,380.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,655,535.40	1,213,111.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,300,787.70	1,955,898.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,300,787.70	1,955,898.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,012,209.50	1,623,743.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,032.00	837,126.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,808.20	100,695.30

**БАЯНТҮМЭН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,786.00	115,868.30
2104	Хангамж, бараа материалын зардал	41,845.80	57,853.70
2105	Нормативт зардал	1,356.00	8,281.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,559.50	31,804.00
2107	Томилолт, зочны зардал	11,167.00	12,791.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,836.70	9,371.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,818.10	449,950.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,288,578.20	332,155.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,180,810.60	1,816,368.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	789,574.30	1,506,131.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	789,574.30	1,506,131.00
2200	Дотоод эх үүсвэрээр	789,574.30	1,506,131.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-789,574.30	-1,506,131.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-36,900.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	36,900.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	354,336.30	310,237.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	250,657.90	604,994.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	604,994.20	915,232.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,087,536.40	3,141,457.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,521,792.10	1,395,896.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,437,623.50	1,313,930.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	859,925.60	837,126.76
210101	Үндсэн цалин	438,921.60	436,346.92
210102	Нэмэгдэл	328,171.40	320,572.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,960.00	28,821.69
210104	Урамшуулал	55,872.60	51,385.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,975.70	100,695.26
210201	Тэтгэврийн даатгал	75,663.40	67,795.09
210202	Тэтгэмжийн даатгал	8,828.00	8,183.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,062.60	5,319.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,765.60	4,083.11
210205	Эрүүл мэндийн даатгал	17,656.10	15,314.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,178.30	115,569.27
210301	Гэрэл, цахилгаан	54,269.30	48,682.04
210302	Түлш, халаалт	72,629.00	63,835.57
210303	Цэвэр, бохир ус	4,280.00	3,051.66
210304	Байрны түрээс	0	0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,782.30	27,385.25
210401	Бичиг хэрэг	3,917.30	3,891.25
210402	Тээвэр, шатахуун	20,477.90	16,485.43
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,866.00	1,923.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757.80	538.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,763.30	4,547.27

**БАЯНТҮМЭН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2105	Нормативт зардал	1,401.40	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401.40	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,698.50	30,533.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,156.30	6,021.20
210602	Тавилга	550.00	550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661.30	653.40
210604	Урсгал засвар	23,330.90	23,308.40
2107	Томилолт, зочны зардал	10,968.70	10,295.30
210702	Дотоод албан томилолт	10,968.70	10,295.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,184.00	9,371.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,368.80	2,841.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	399.40	0
210803	Даатгалын үйлчилгээ	342.30	289.13
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224.10	223.57
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	141.60	121.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,409.40	634.40
210807	Газрын төлбөр	5,277.40	5,262.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	21.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,509.00	182,954.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	245,896.90	182,624.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	612.10	330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	323,598.70	321,395.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	239,430.10	239,430.10
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	239,430.10	239,430.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,168.60	81,965.46
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	222.60	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,247.40	26,247.37
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55,210.80	54,108.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,487.80	1,610.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,241,728.20	1,506,131.01
223001	Бусад хөрөнгө	2,241,728.20	1,506,131.01
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	84,586.00	0
230001	Эргэж төлөгдөх зээл	84,586.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,848,106.30	3,414,692.79
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,885,652.80	3,108,301.11
320001	Орон нутгийн төсвөөс	1,835,877.40	2,114,478.74
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,049,775.40	993,822.37
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	651,772.80	102,010.98
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,966.00	50,315.98
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,300.00	51,695.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	555,506.80	0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	310,680.70	204,380.70
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	310,680.70	204,380.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	93,314.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	605,980.43
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	64	64
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,529.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,529.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	197,769.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	299.00
210302	Түлш, халаалт	299.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,468.44
210401	Бичиг хэрэг	99.00
210402	Тээвэр, шатахуун	30,369.44
2105	Нормативт зардал	8,281.74
210502	Хоол, хүнс	8,281.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,271.00
210604	Урсгал засвар	1,271.00
2107	Томилолт, зочны зардал	2,496.00
210702	Дотоод албан томилолт	2,496.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,953.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,953.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,759.89
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,759.89
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,759.89
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,529.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	208,529.21
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,580.52
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,140.58
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,808.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13.0 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн. Үүнд:

- "Баянтүмэн хөгжил" ОНӨҮГ-ын тайланг зөрүүтэй нэгтгэн илэрхийлсэн.

Аудитаар нийт 800.5 сая төгрөгийн 4 зөрчил² илэрсэнд 16.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 626.9 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 156.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

"Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" төсөл арга хэмжээнд сумын ОНХС-гийн хөрөнгөнөөс 20.0 сая төгрөгийг төлөвлөн, гүйцэтгэлээр 16.7 сая төгрөг /туршлага судлахад 3.8 сая төгрөг, ЭМТ-ийн ажилчид БНХАУ-ын Манжуур хотын эмнэлэгт үзлэг оношлогоо хийлгэхэд 3.5 сая төгрөг, Төрийн албан хаагчдын спортын арга хэмжээнд 2.0 сая төгрөг, сургалтын арга хэмжээнд 7.4 сая төгрөг/-ийг зарцуулсан байна. Уг төсөл, арга хэмжээ иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, ... зардал, арга хэмжээ", Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 76.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 90.0 сая төгрөгөөр 3 ажил, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 536.9 сая төгрөгийн 6 арга хэмжээ хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн орлого төлөвлөлт, гүйцэтгэлийн хэрэгжилттэй холбоотой.

1. **Илрүүлэлт:** Сумын нийт орлого 2,152.7 сая төгрөг болж 77.4 сая төгрөг буюу 3.7 хувиар давж биелсэн байна. Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл бууны татвар 42.5 хувь буюу 0.5 сая төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамж 60.0 хувь буюу 0.8 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай АМНАТ 100 хувь буюу 15.0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Мөн газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөгөөгүй, гүйцэтгэлээр 15.6 сая төгрөгийг орлого төвлөрсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах зөвлөмж өгөх

Батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Илрүүлэлт: Батлагдсан төлөвлөгөөт 125.0 сая төгрөгийн 5 бараа, ажил үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төлөвлөгөөт худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хамрах хүрээний байгууллагын тайланг зөрүүтэй нэгтгэсэн	1	13.0	1	13.0	-	-	1	13.0	-	-	-	-
Дүн	1	13.0	1	13.0	-	-	1	13.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-гийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээнд зарцуулсан	1	16.7	1	16.7	-	-	-	-
ТТЗ-ийн хүрэх үр дүнг ханган ажиллаагүй	1	626.9	-	-	1	626.9	-	-
Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэн ажиллаагүй	1	31.9	-	-	-	-	1	31.9
Батлагдсан төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй	1	125.0	-	-	-	-	1	125.0
Нийт дүн	4	800.5	1	16.7	1	626.9	2	156.9